



МОНГОЛЫН РАГБИГИЙН ХОЛБОО

2016

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Азийн ЕБС-н Спорт
Наадам 2016
Хонг Конг

ОУОХ-ны Эв Санааны
Хорооны сургалт
Рагби 7

БХЯ-ны харьяа
АЛДАР СПОРТ
ХОРОО-той хамтын
ажиллагаа

Агуулга

МРХ-ны 2016 оны үйл ажиллагааны тайлан

Нэг. Сургалт семинар зохион байгуулсан байдал

1. Дасгалжуулагч болон шүүгчийн 2-р шатны сургалт
2. Дэлхийн Рагбигийн Холбооны сургагч багш бэлтгэх сургалт
3. Хүчний бэлтгэлийн дасгалжуулагчийн 2-р шатны сургалт
4. Рагбигийн анагаахын анхан шатны сургалт

Хоёр. Тэмцээн уралдаан зохион байгуулсан байдал

1. Цасны рагби 2016 АШТ
2. Легионер тамирчдын нэрэмжит АШТ
3. ЕБС-иудын ӨАШТ 2016
4. Азийн ЕБС-иудын хоёрдугаар АШТ
5. Рагби 7 УАШТ
6. Рагби 15 УАШТ

Гурав. Хамтын ажиллагаа

1. Японы засгийн газрын JENESYS 2.0 хөтөлбөрт МРХ-ны тамирчин оролцлоо
2. Эмэгтэй рагбигийн тамирчдад мэндчилгээ дэвшүүлээ
3. Олимп болоход 100 хоног өдөрлөгт Рагбид оролцох нь хөтөлбөрийг зохиолоо
4. Монголын Зуслангуудын Холбоотой хамтран Рагбид оролцох нь хөтөлбөрийг хэрэгжүүлээ
5. Азийн Рагбигийн стратеги хөгжлийн зөвлөх Монголын рагбигийн хөгжлийг үзэж танилцлаа
6. AVE студитай хамтран богино хэмжээний кино бүтээлгэлээ
7. Алдар спорт хороотой хамтын ажиллагааны гэрээ байгууллаа
8. Olympic Solidarity Олон улсын олимпийн хорооны ивээл дор болсон Рагби 7-ийн сургалтыг амжилттай зохион байгууллаа

СУРГАЛТ СЕМИНАР

Дасгалжуулагч болон шүүгчийн 2-р шатны сургалт

Дэлхийн Рагбигийн Холбооны багш, дасгалжуулагч сургагч Жин Тонг болон Монголын Рагбигийн Холбооноос хамтран сонгон шалгаруулсан 7 оролцогчдод 2016 оны 2 сарын 11-14-ний өдрүүдэд дасгалжуулагчийн 2-р шат, мөн шүүгчийн 2-р шатны сургалтыг амжилттай зохион байгуулаа.

Тус сургалтыг МҮОХ болон Монголын Рагбигийн Өсвөрийн АШТ-ий хошой аварга болсон “Аварга” сургууль дэмжин, сургалт зохион байгуулах сургалтын танхимаар хангаж өгсөн юм.

Дэлхийн Рагбигийн Холбооны сургагч багш бэлтгэх сургалт

Монголын Рагбигийн Холбооны энэ оны томоохон зорилтын нэг бол багш дасгалжуулагчдыг бэлдэх, тэдний ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэн ажилласан билээ. Дэлхийн Рагби болон Азийн Рагбигийн Холбоотой хамтын ажиллагааны хүрээнд монголдоо Дэлхийн Рагбигийн Холбооны 1-р шатны сургалтыг явуулж, гэрчилгээ олгох эрхийн сургалтанд анх удаагаа 2 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон юм. Хүчний дасгалжуулагчийн сургалтанд МРХ-ны гүйцэтгэх захирал Г.Дашдэндэв хамрагдах болсон бөгөөд сургалтын хувьд хүчний бэлтгэлийг хэрхэн төлөвлөх, тамирчдын биеийн онцлогт болон гэмтэл бэртлээс сэргийлэх, нөхөн сэргээх, рагбигийн спортын төрлөөс хамааруулж бэлтгэл сургуулилт хийлгэхэд амжилттай суралцаж чадсан билээ.

Рагбигийн анагаахын анхан шатны сургалт

2016 онд зохиогдсон энэхүү рагбигийн спортын анагаахын сургалтыг зохион байгуулсанаар тамирчдын эрүүл мэндийг хянах, гэмтэл бэртлээс сэргийлэх, бэртлийн үед хэрхэн тамирчдад анхан шатны тусламжийг үзүүлж сурахад гол зорилго оршсон юм. МРХ-ны урилгаар өнгөрөгч 7 сарын 26-27-ны өдрүүдэд МҮОХ-ны байранд Азийн Рагбигийн Холбооны анагаахын сургалт хариуцсан доктор Азрил Саязван удирдан явуулсан юм.



ТЭМЦЭЭН УРАЛДААН



Цасны рагби 2016 АШТ

Жил бүр уламжлал болгон зохион байгуулж ирсэн Цасны Рагби 2016 АШТ 4 долоо хоногийн турш амжилттай зохион байгуулагдлаа. Энэ жилийн аварга шалгаруулах тэмцээнд 7 клубын 150 гаруй тамирчин 2 дивизонд хуваагдан тойргийн системээр тоглож 3 цомын төлөө чансаагаараа өрсөлдсөн билээ. Цасны Рагби 2016 АШТ-ий Боул цомын төлөө Техник технологийн коллежийн Ирвэсүүд РК, Аварга дээд сургуулийн Аварга Зөгийнүүд РК-ын эсрэг тоглож 15-0 онооны харьцаатайгаар хожиж Боул цом, мөнгөн шагналын эзэн болсон. Плайт цомын төлөө Хөх Толбот Дайчид РК болон Ангууч Арслангууд РК-үүд өрсөлдөн 5-10 оноогоор Ангууч Арслангууд РК тэргүүлж Плайт цом, мөнгөн шагналын эзэн боллоо. Аваргын цомын төлөө нэг ч хожигдолгүй тэмцээнийг тэргүүлсэн Хан-Уул РК, Анхдагч Чононууд РК нар тоглож Хан-Уул РК 19-10 онооны харьцаатайгаар хожсоноор Цасны рагбигийн хошой аварга болж чадлаа.

Легионер тамирчдын нэрэмжит АШТ

Монголын Легионер Тамирчдын Холбоо үүсгэн байгуулагдаж МРХ-той хамтран Легионер Тамирчдын нэрэмжит анхны тэмцээнээ амжилттай зохион байгуулсан билээ. Легионер Тамирчдын нэрэмжит АШТ-ийг жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар шийдсэн бөгөөд 4 сарын 2-3 өдрүүдэд Бейсболын талбайд рагби 10 төрлөөр явуулж МРХ-ны харьяа эрэгтэй 8 баг, эмэгтэй 4 баг оролцож аваргуудаа шалгаруулсан. Эрэгтэй багууд 2 дивизон болсон ба 2-р дивизионы аваргаар Ирвэсүүд РК тэргүүлсэн бол эмэгтэйчүүдийн Ангууч Арслангууд РК-ын эмэгтэй баг, эрэгтэйчүүдийн 1-р дивизионы аварга багаар Хан-Уул РК шалгарч цомын эзэд болсон байна.

Рагби 7 УАШТ 2016

Монголын Рагбигийн Холбооны Рагби 7 УАШТ 2016 оны аваргуудаа тодруулж тэмцээнээ амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд эрэгтэй 5, эмэгтэй 3 баг мэдүүлгээ өгөн оролцсон билээ. Эмэгтэй багуудын тоглолтын хувьд залуучуудын АШТ ангиллаар өрсөлдөж 3-р байрт Аварга Зөгийнүүд РК-ын эмэгтэй баг, хоёрдугаар байрт Хан-Уул РК-ын эмэгтэй баг, тэргүүн байрыг Анхдагч Чононууд РК-ын эмэгтэй баг тус тус эзэлсэн. Харин эрэгтэй төрөлд 5-р байр Аварга Зөгийнүүд РК, 4-р байр Хөх Толбот Дайчид РК, 3-р байр Хан-Уул РК, 2-р байр Анхдагч Чононууд РК, 1-р байрыг Ангууч Арслангууд РК эзэлж Рагби 7 УАШТ-ий түрүүг 4 удаа хүртэж нэгэн рекордын эзэн болж байна.

ЕБС-н ӨСВӨРИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН

Олимпийн жилийг угтан, Монголын Рагбигийн Холбооноос 7 дахь жилдээ зохион байгуулсан нийслэлийн ерөнхий боловсролын 8 сургуулийн эрэгтэй 6 баг, эмэгтэй 5 багийн 200 гаруй өсвөрийн тамирчин хурд хүч, авхаалж самбаагаа 2 долоо хоногийн турш сорин үзэж шилдгүүдээ тодруулсан билээ.

Тэмцээний эмэгтэй баг тамирчид Олимпийн төрөлд багтсан Рагби 7 төрлөөр өрсөлдөж 1-р байрыг Аварга лицей сургууль, 2-р байрыг Ирээдүй цогцолбор сургууль, 3-р байрыг Амгалан цогцолбор сургууль тус тус эзэллээ. Эрэгтэй баг тамирчид Рагби 10 төрлөөр өрсөлдөж 1-р байрыг Ирээдүй цогцолбор сургууль, 2-р байрыг Олон улсын холимог сургууль, 3-р байрыг Аварга лицей сургууль шалгарлаа. Тэмцээний шилдэг эрэгтэй, эмэгтэй тамирчнаар Ирээдүй цогцолбор сургуулийн Б.Мөнх-Эрдэнэ, Б.Хоролсүрэн нар тодорсон юм.

Тэмцээний онцлогийг дурьдвал тэмцээнд оролцсон хөвгүүдийн багуудын шилдэг тамирчдаас Өсвөрийн шигшээ багийг бүрдүүлэн Хонг Конгод 7 сарын 22-26-ны өдрүүдэд зохиогдох Азийн ЕБС-н дундах спорт наадамд рагбигийн төрөлд өрсөлдөх багийг сонгон шалгаруулсан болно.

2016 оны ЕБС-иудын тэмцээнийг Нийслэлийн Боловсролын Газар дэмжлэг үзүүлэн хамтран зохион байгуулсан бол тэмцээнд байр эзэлсэн багуудад өргөмжлөл, шилжин явах цом, медал, мөнгөн шагналыг гардуулж шинэ залуу тамирчдаа урамшуулан дэмжсэн ААН байгууллага, хувь хүмүүстээ талархсанаа илэрхийлэе.



АЗИЙН ЕБС-н СПОРТ НААДАМ ХОНГ КОНГ

Монголын 18-аас доош насны өсвөрийн шигшээ баг анх удаагаа олон улсын тэмцээнээ Олимпийн рагби 7 төрлөөр оролцож арвин их туршлага хуримтлуулан амжилттай оролцлоо.

Манай баг тамирчид Шри Ланка, Камбож, Малайз зэрэг улсын өсвөрийн багуудтай нэг бүсэд орон тоглосон бөгөөд бүсийн тоглолтын дүнгээрээ 5 байрны төлөө БНХАУ-ын багтай тоглож хожигдон 7 байрны төлөө Гуам улсын өсвөрийн шигшээ багтай тоглосон билээ.

Манай өсвөрийн шигшээ баг нийтдээ 5 тоглолтыг хийж шагналт 8 байранд шалгарсан юм. Монголын Рагбигийн Холбоо нь Хонг Конгийн Рагбигийн Холбоо болон Азийн Сургуулиудын Холбооноос зохион байгуулсан Азийн Сургуулиудын Рагби 7 АШТ-нд залуу баг тамирчдаа бэлтгэн оруулж чадсан бөгөөд манай баг тамирчдыг дэмжсэн ААН байгууллага, хувь хүмүүст баярлан талархаж байгаагаа идэрхийлье.

Манай баг тамирчид 7 сарын 23,24-ний өдрүүдэд тэмцээндээ оролцсон бол 25-ны өдөр бусад багуудын хамт Хонг Конгийн далайн паркаар аялан тоглосон билээ.



РАГБИ 15 ҮАШТ

Монголын Рагбигийн Холбооны нэрэмжит 4 дэх удаагийн Рагби 15 төрлийн ҮАШТ болон эмэгтэй Рагби 7 төрлийн ҮАШТ-ийг хамтад нь зохион байгуулсан билээ.

Рагби 15 төрлийн ҮАШТ нь 2 үе шаттайгаар явагдсан бөгөөд рагби нэгдүгээр тойргийн тоглолтууд 2016 оны 6 сард явагдсан бол хоёрдугаар тойргийн тоглолтууд 8,9 саруудад явагдаж дүнгээ гаргалаа. Хоёрдугаар дивизоны аваргаар Ирвэсүүд РК тэргүүлсэн бол нэгдүгээр дивизоны гутгаар байрыг Хан-Уул РК эзэлж, аваргын цомын төлөө Ангууч Арслангууд РК, Анхдагч Чононууд РК нар өрсөлдөж нийлбэр оноогоор Анхдагч Чононууд РК тэргүүлж анх удаагаа Рагби 15 ҮАШТ-ий цомоо өргөсөн билээ.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

Японы Засгийн Газрын JENESYS 2.0 хөтөлбөрт MPX-ны тамирчин оролцлоо

Японы засгийн газрын дэмжлэгтэйгээр зохион байгуулж ирсэн JENESYS 2.0 хөтөлбөрт анх удаагаа MPX-оос МҮОХ-ны шугамаар Ангууч Арслангууд РК-ын Е.Бямбабүтэд тус хөтөлбөрт хамрагдахаар болсон бөгөөд Япон улсыг зорьж Япон улсын түүх соёл, зан заншил болоод олимпийн хөтөлбөртэй танилцан, монголын рагбиг сурталчилсан билээ.

Эмэгтэй рагбигийн тамирчдад мэндчилгээ дэвшүүлээ

Монголын Рагбигийн эмэгтэй тамирчдын төлөөлөл болох Ангууч Арслангууд РК-ын Н.Түвшинжаргалын маань Ази тивийн рагбигийн шигшээ багуудын тамирчид, дасгалжуулагч гэх мэт бусад эмэгтэй төлөөлүүдтэй нэгдэн Ази тивийн рагбигийн бүх бүсгүйчүүдэдээ олон улсын эмэгтэйчүүдийн баярыг угтан мэндчилгээ дэвшүүлсэн юм



Азийн Рагбигийн Стратеги Хөгжлийн Зөвлөх Монголын Рагбигийн хөгжлийг үзэж танилцлаа



Холбооны урилгаар Азийн Рагбигийн Стратеги Хөгжлийн Зөвлөх Мэтт Окли Монголын Рагбигийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, тэмцээн уралдаан хэрхэн зохион байгуулагддаг зэрэгтэй танилцсан билээ. Тэрээр Монголын Рагбигийн Холбооны хэрэгжүүлж байгаа ажил хэргийг өндрөөр үнэлэн, Рагбид оролцох нь хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа болон Алдар спорт хороотой хамтран монголын цэрэг армид рагби спортыг хөгжүүлэхээр болсон үйл явдлуудад өөрийн биеэр оролцож сайшаасан юм.

AVE студитэй хамтран богино хэмжээний кино бүтээлгэлээ

AVE студийн хамт олны бүтээсэн богино хэмжээний кинонд Монголын Рагбигийн 3 тамирчин оролцож бэлтгэл сургуулилт хэрхэн явагддаг

болон яагаад рагбигийн спортыг сонирхож хичээллэх болсон талаараа сонирхолтой яриаг өрнүүлж чадсан нь шинэ залуу тамирчдыг улам татаж чадсан юм.



Монголын Зуслангуудын Холбоотой хамтран Рагбид оролцоё хөтөлбөрийг хэрэгжүүлээ

Дэлхийн Рагбигийн Рагбид оролцох нь /Get Into Rugby/ хөтөлбөрийг Монголын Рагбигийн Холбоо нь амжилттай хэрэгжүүлж байгаа билээ. Монголын Рагбид оролцох нь хөтөлбөрийг Монголын Зуслангуудын Холбоотой хамтран зуны амралтаар хүүхдийн зуслангуудад рагбигийн спортыг таниулан рагбид оролцуулахаар 3 жилийн хугацаатай санамж бичигт гарын үсэг зурж, зуслангийн багш нарт хэрэглэлээ гардуулан сургалтуудаа амжилттай явуулаад байна.




РАГБИД ОРОЛЦОХ НЬ ХӨТӨЛБӨР

Олимп болоход 100 хоног өдөрлөгт Рагбид оролцох нь хөтөлбөрийг зохиолоо

Монголын Рагбигийн Холбоо нь Монголын Үндэсний Олимпийн Хороотой хамтран Бразилийн нийслэл Рио Де Жанеро хотноо зохиогдох зуны олимпийн XXXI наадам эхлэхэд 100 хоног үлдж байгааг тохиолдуулан мөн энэ жилийн олимпод рагби спорт нь албан ёсоор багтаж байгааг онцлон Рагби спортыг таниулан сурталчлах, хүүхэд залуучуудад рагбигийн спортоор биеийн хөгжил, баг хамт олноор ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2016 оны 4 сарын 27-ны өдөр Үндэсний Цэцэрлэгт Хүрээлэнгийн Хөлбөмбөгийн талбайд Рагбид оролцох нь хөтөлбөрийг 250 гаруй хүүхэд багачуудад амжилттай танилцууллаа.



Арга хэмжээний үеэр МҮОХ удирдлагууд оролцсон бөгөөд Монголын Рагбигийн Холбооноос төрөн гарсан рагбигийн легионер тамирчдад болон шилдэг тамирчдад МҮОХ-ны Алтан медалийг гардуулсан нь тэмдэглэлт үйл явдал болсон зэргийг дуулгахад таатай байна.



NATIONAL OLYMPIC
COMMITTEE OF MONGOLIA





Алдар Спорт Хороотой хамтын ажиллагааны гэрээ байгууллаа

МРХ нь Батлан Хамгаалах Яамтай хамтын ажиллагааны хүрээнд рагбигийн хөгжилд түүхэн чухал Санамж бичгийг Алдар спорт хороотой хамтран байгууллаа. Энэхүү санамж бичгийн хүрээнд Монгол улсад рагбиг цэрэг, армид хөгжүүлэх баримт бичиг болсон бөгөөд МРХ-ны дэргэдэх Цэргийн Рагбигийн Холбоог байгуулагдаад байгааг дуулгахад баяртай байна.

2016 оны 11 сараас эхлэн рагбигийн спортыг танилцуулах сургалтыг зохион байгуулах төдийгүй анхны цэргийн рагбигийн багийг бүрдүүлж бэлтгэлжилтийг эхлүүлээд байна.



**БАТЛАН
ХАМГААЛАХЫН ЯАМ**



OLYMPIC SOLIDARITY, Олон улсын олимпийн хорооны ивээл дор болсон Рагби 7-ийн сургалтыг амжилттай зохион байгууллаа

Олимпийн төрлийн багийн спортыг Монголд хөгжүүлэх, спортыг хөгжүүлэх багш дасгалжуулагч нарт онол болон практик хослуулсан олон улсын түвшний сургалтын стандартаас суралцуулах, цаашлаад хүүхэд залуучуудыг энэхүү төрлөөр хичээллүүлж, биеийн хөгжил, багаар ажиллах чадвар болон тэсвэр хатуужилд сурган дотоод болон гадаадын тэмцээн уралдаанд оролцох баг тамирчдыг бэлтгэж, Олимпийн төрлөөр эрх авах баг тамирчдыг бэлтгэхэд гол зорилго оршсон болно.



Olympic Solidarity хөтөлбөрийн хүрээнд Рагби 7 олимпийн төрлийн сургалт нь Олон Улсын Олимпийн Хороо болон Дэлхийн Рагбигийн Холбооноос хамтран зохион байгуулж байгаа сургалт бөгөөд энэхүү сургалтанд хамрагдсанаар Дэлхийн Рагбигийн Холбооны 1-р шатны Рагби 7 буюу Олимпийн төрлийн дасгалжуулагч болон Рагби 7 төрлийн хүчний бэлтгэлийн дасгалжуулагч болж дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн дасгалжуулах эрхийн гэрчилгээг болон Олон улсын олимпийн хорооноос батламжлагдсан “Эв санааны нэгдлийн хороо”-ны гэрчилгээг нийт 31 багш, дасгалжуулагч гардан авсан юм.

Сургалтыг удирдах багш: Дэлхийн Рагбигийн Холбооны сургагч багш Гайт Жалажел удирдан явуулах ба МРХ-ны багш дасгалжуулагч, Дэлхийн Рагбигийн Холбооны сургагч багш Г.Дашдэндэв болон МРХ-ны дасгалжуулагч Н.Энх-Амгалан нар хамтран сургалтыг явуулсан юм.



Сургалтанд хамрагдсан нийт багш нарыг хэрэглэл, гарын авлага, бөмбөг, мөн нэгдсэн унаагаар үйлчилж, өдрийн хоол зэргээр хангасан юм.





МОНГОЛЫН РАГБИГИЙН ХОЛБОО

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
Чингисийн өргөн чөлөө,
Олимпийн хороо, 104 тоот
Утас: 1134-1208, 9811-3696, 9999-3639
И-мэйл: austin.gansukh@mrfu.mn
Веб хаяг: www.mrfu.mn



MONGOLIAN
RUGBY